

A horizontal bar composed of several colored segments: yellow, light blue, dark blue, yellow, grey, dark blue, light blue, and green.

# 2022 оны Солонгос хэлний боловсролын төвийн элсэлтийн удирдамж

СүнЧонХян Их Сургууль  
Солонгос хэлний боловсролын төв



# Гарчиг

## 2022 оны Солонгос хэлний боловсролын төвийн элсэлтийн удирдамж

- 03р Солонгос хэлний боловсролын төвийн танилцуулга
- 03р Солонгос хэлний боловсролын төвийн хөтөлбөр
- 04р Өргөдөл хүлээн авах болон эрдмийн хуваарь
- 04р Элсүүлэн авах хүний тоо
- 04р Өргөдөл гаргах эрхийн талаар
- 05р Элсэн орох шат дамжлага
- 06р Хураалгах бичиг баримт
- 07р Өргөдөл гаргагчын анхаарах зүйл
- 08р Сургалтын төлбөр болон дотуур байрны төлбөр
- 08р Бусад зүйлийн талаарх танилцуулга(\*төлбөр буцаалт)
- 09р Баримт бичиг бүрдүүлэн өгөх болон лавлах хаяг

# 1. Солонгос хэлний боловсролын төвийн танилцуулга

Солонгос хэлний боловсролын төв нь СүнЧонХян их сургуулийн дэргэдэх Солонгос хэлний сургалтын хүрээлэн юм. Солонгос хэлний боловсролын төвөөс хэл сурж буй гадаадын иргэнээр зогсохгүй Солонгос улсад оршин сууж буй гадаадын иргэнд бодит хэрэглээний Солонгос хэлийг хэвшүүлэн Солонгосын соёлыг суралцаж болох сургалтын хөтөлбөрийг зохион байгуулж байгаа юм.

Солонгос хэлний хичээл нь 1 жилд 4 улирлаар явагддаг бөгөөд, нэг улирал нь долоо хоногт 5 өдөр, 10 долоо хоног, 200 цагаар явагддаг юм.

Төв байгуулгаас Солонгосын соёлын туршлага, Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт(TOPIK) дэмжлэг, олон төрлийн гадаад оюутны үйл ажиллагаа зэргийг мөн явуулж байгаа юм.

※ Нарийн зүйлийг нүүр хуудаснаас шалгахыг хүсье. <http://sgee.sch.ac.kr>

# 2. Солонгос хэлний боловсролын төвийн хөтөлбөр

Ангилал	Хуваарь	Агуулга
• Солонгос хэлний хичээл	Даваа~Баасан	<ul style="list-style-type: none"> <li>▶ Солонгос улс доторх их сургуульд ороход шаардлагатай солонгос хэлний эрчимжүүлсэн сургалт</li> <li>▶ Долоо хоногт яриа 8 цаг, унших 4 цаг, сонсох 4 цаг, бичих 4 цагаас бүрдсэн</li> <li>▶ 1 түвшин~6 түвшин хүртэл тус бүрээр хичээл явагдана</li> <li>▶ 1~2 түвшний ном нь СүнЧонхян их сургуулиас хэвлэн гаргасан солонгос хэлний номыг ашиглана</li> </ul>
• Солонгосын соёлын туршлага	Улирал бүрт 1~2 удаа	<ul style="list-style-type: none"> <li>▶ Орон нутгийн баяр наадам, Солонгосын уламжлалт соёлыг мэдрэх боломжоор хангана</li> <li>▶ Солонгосын аялал жуулчлалын газруудаар зочилж, тоглолт үзэх</li> </ul>
• Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт(TOPIK) дэмжлэг	Жилд 6 удаа	<ul style="list-style-type: none"> <li>▶ Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт(TOPIK)-нд зориулан түвшин бүрээр үнэгүй тусгай хичээлийг 2~3 долоо хоног явуулана</li> <li>▶ Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт(TOPIK) өгөх үед үнэгүй ирж очих автобус явна</li> </ul>
• Бусад үйл ажиллагаа	Жилийн аль ч үед	<ul style="list-style-type: none"> <li>▶ Солонгос хэлний бичгийн тэмцээн : Солонгос хэлний бичих ур чадвараа харуулах боломжийг олгох болон суралцах сэдлийг бэхжүүлэх</li> <li>▶ Дэлхийн олон үндэстний наадам : Улс орон бүрээр майхангаар ханган өөрсдийн соёл, хоол хүнсийг танилцуулах боломжоор хангана</li> <li>▶ Дүнгээр тэргүүлэгчийн шагнал</li> <li>▶ Олон төрлийн гадаад оюутны хөтөлбөрт оролцох боломжоор хангана</li> </ul>

※ Дээрх агуулгын хэсэг нь нөхцөл байдлаас хамааран өөрчлөгдөж болно

### 3. Өргөдөл хүлээн авах болон эрдмийн хуваарь

Ангилал		2022 оны Хавар	2022 оны Зун	2022 оны Намар	2022 оны Өвөл
Хичээл эхлэх өдөр		2 сарын 28 (Даваа)	5 сарын 16 (Даваа)	8 сарын 29 (Даваа)	11 сарын 14 (Даваа)
Хичээл дуусах өдөр		5 сарын 6 (Баасан)	7 сарын 22 (Баасан)	11 сарын 4 (Баасан)	1 сарын 20 (Баасан)
Өргөдөл болон элсэлтийн материал хүлээн авалт дуусах өдөр ※ Хэзээ ч хүсэлт гаргах боломжтой	Дотоодод оршин суугч	2 сарын 4 (Баасан)	4 сарын 22 (Баасан)	8 сарын 5 (Баасан)	10 сарын 21 (Баасан)
	Гадаад оршин суугч	12 сарын 31 (Баасан)	3 сарын 18 (Баасан)	7 сарын 1 (Баасан)	9 сарын 16 (Баасан)
Төлбөр төлөх хугацаа		Тусад нь мэдэгдэнэ	Тусад нь мэдэгдэнэ	Тусад нь мэдэгдэнэ	Тусад нь мэдэгдэнэ

※ Дээрх агуулгын хэсэг нь нөхцөл байдлаас хамааран өөрчлөгдөж болно

### 4. Элсүүлэн авах хүний тоо

#### ▶ Цөөн хүн

※ Элсүүлэн авах(тэнцсэн) хүний тоонд хязгаар байхгүй бөгөөд, материалын шалгалтанд тэнцсэн тохиолдолд бүгд тэнцсэнд тооцоно

### 5. Өргөдөл гаргах эрхийн талаар

**A** Дотоод/гадаадын ахлах сургуулийг төгсөгч(төгсөх гэж буй хүн) мөн хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн академик боловсрол эзэмшигчээр, 12 жилээс дээш боловсрол(бага/дунд/ахлах ердийн сургалтын хөтөлбөр) эзэмшигч

※ Зөвхөн, 12 жилээс бага сургуулийн системийг нэвтрүүлсэн улс орнуудын бага-дунд сургуулийн боловсрол эзэмшсэн гадаадын иргэн нь манай улсын ахлах сургуулийн төгсөгчидтэй ижил боловсрол эзэмшсэн гэж хүлээн зөвшөөрөнө

※ Бага сургуулийн өмнөх боловсролын байгуулга(ясли, цэцэрлэг), хэлний бэлтгэл, насан туршийн боловсролын төв зэрэг боловсролын байгууллагуудад суралцсан хугацааг хүлээн зөвшөөрдөггүй

※ Төгсөх шалгалт, гэрээр суралцах, онлайн сургалт зэргийг хүлээн зөвшөөрөхгүй

**B** БНСУ-н виз(VISA) авахад асуудалгүй гадаадын иргэн мөн хууль ёсны оршин суух эрх эзэмшигч



## 6. Элсэн орох шат дамжлага

### Элсэн орогчид нэр дэвшүүлэх болон элсэлтийн өргөдөл гаргах боломжтой эсэхийг шалгах

- ▶ Хамтран ажиллагч байгуулгын санал, хууль ёсны оршин суугч зэрэг, хэн болох нь тогтоогдсон хүн л элсэн орох хүсэлт гаргах боломжтой
- ※ Элсэх өргөдөл гаргах боломжтой эсэхийг урьдчилан лавлах

### Элсэлтийн удирдамжтай танилцах

- ▶ Элсэлтийн хүслт гаргахын өмнө элсэлтийн удирдамжын агуулгатай заавал танилцах
- ※ Танилцаагүйгээс үүдэн үүссэн хохирлыг өөрөө хариуцана

### Элсэлтийн өргөдөл болон элсэлтийн баримт бичгийг ирүүлэх

- ▶ Тухайн семестр бүрээр заасан хугацаанд элсэлтийн өргөдөл болон элсэлтийн баримт бичгийг ирүүлэх
- ※ Хугацааг мөрдөөгүй тохиолдолд элсэлтийн өргөдөл хүлээн авахгүй

### Элсэлтийн баримт бичиг шалгах

- ▶ Элсэлтийн өргөдөл болон элсэлтийн баримт бичгээр дамжуулан өргөдөл гаргагчын өргөдөл гаргах эрх, санхүүгийн чадвар, суралцах төлөвлөгөө, ирүүлсэн баримт бичигт ямар нэгэн асуудал байгаа эсэх зэргийн цогц чанарыг шалган цэнцэх эсэхийг шийдэнэ

### Тэнцэгчийг мэдэгдэх

- ▶ Хувийн E-MAIL эсвэл хамтрагч байгуулгаар дамжуулан тэнцсэн эсэхийг мэдэгдэнэ

### Төлбөх төлөх

- ▶ Мэдэгдлийн дагуу заасан хугацаанд төлбөрөө төлөх
- ※ Заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд бүртгэлээс татгалзсан гэж үзнэ

### Виз(VISA) болон оршин суух эрхийн өөрчлөлтөнд бүртгүүлэх

- ▶ Мэдэгдлийн дагуу виз(VISA) болон оршин суух эрхийг өөрчлөхөд бүртгүүлэх
- ※ Хамаарах хүнд

### Солонгос улсад орж ирэх

- ▶ Мэдэгдлийн дагуу заасан хугацаанд Солонгос улсад орж ирэх
- ※ Хамаарах хүнд

### Элсэн орох

## 7. Хураалгах бичиг баримт

Хэн	Шаардлагатай бичиг баримт	Тайлбар
Солонгос хэл суралцагч	<p>(1) Солонгос хэлний тэнхимд элсэх хүсэлт 1 хувь [*сургуулийн загвар]            ※ Цээж зураг, хувийн танилцуулга, гадаадад суралцах зардлын барьцаа, сургалтын төлбөрийг нэмэгдүүлэх төлөвлөгөө зэрэг орно</p> <p>(2) Ахлах сургууль төгссөн(төгсөх) баталгааны эх хувь 1            ※ Дипломын хувьд хуулбар хэлбэрээр ирүүлэх боломжтой</p> <p>(3) Ахлах сургуулийн бүх дүн эх хувь 1</p> <p>(4) Ахлах сургууль төгссөнг тодорхойлох сүүлийн боловсролын гэрчилгээ эх хувь 1            ※ (2) Ахлах сургууль төгссөн гэрчилгээ, (3) ахлах сургуулийн дүнгийн гэрчилгээг апостиль гэрчилгээгээр авах            ※ Их сургууль(техник мэргэжлийн коллеж) төгссөн тохиолдолд их сургууль (техник мэргэжлийн коллеж)-н төгссөн талаарх апостиль өгөх боломжтой</p> <p>(5) Хүсэлт гаргагчийн гадаад паспортны хуулбар 1 хувь</p> <p>(6) Хүсэлт гаргагчийн гадаад иргэний үнэмлэхний хуулбар 1 хувь            [*Зөвхөн эзэмшигчдэд хамаарана]</p> <p>(7) Гадаадын иргэн гэдгийг батлах бичиг эх хувь 1 [*Хамаарах хүнд]            ※ Иргэний үнэмлэх, гэр бүлийн тодорхойлолт, төрсний гэрчилгээ зэрэг эцэг эх болон хүсэлт гаргагч бүгд гадаадын иргэн гэдгийг батлах бичиг</p> <p>(8) Санхүүгийн баталгаа : Өөрийн нэр дээрх дансанд \$9,000 дээш байршуулсан банкны баталгаа эх хувь 1            ※ Санхүүгийн баталгааны хэмжээ болон гарган авах нөхцөл нь хүсэлт гаргагчийн нөхцөл байдлаас хамааран хэсэг нь өөрчлөгдөж болох бөгөөд, эцэг эхийнхээ нэр дээр авсан тохиолдолд гэр бүлийн тодорхойлолтыг заавал хавсаргах            ※ Хүсэлт гаргагчийн нөхцөл байдлаас хамааран батлан даагч(эцэг эх)-ийн орлого(ажлын газрын тодорхойлолт)-г санхүүгийн баталгааны бичгээр нэмэлтээр хавсаргах магадлалтай</p> <p>(9) Эрүүл мэндийн үзлэг(сүрьеэний шинжилгээ хамаарана)-ийн хуудас эх хувь            [*Гадаад оршин суугчид хамаарана]</p> <p>(10) Үндэсний эрүүл мэндийн даатгалын хуулбар 1 хувь [*Эзэмшигчид хамааран]            ※ Үндэсний эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй хүний хувьд элсэн орсны дараа(*Солонгос улсад орж ирсний дараа) 6 сар өнгөрвөл автоматаар хамрагдах бөгөөд, үндэсний эрүүл мэндийн даатгалд хамрагдах хүртэл хувийн даатгалд хамрагдах шаардлагатай</p> <p>★ Их сургууль(мэргэжлийн коллеж) төгсөгч(сурч байгаа, чөлөө авсан, гарсан, дууссан зэрэг)-ийн нэмэлтээр өгөх бичиг баримт ★</p> <p>(1) Их сургууль(мэргэжлийн коллеж) төгсөлтийн гэрчилгээ болон урч байгаа (чөлөө авсан, гарсан, дууссан зэрэг) тодорхойлолтын эх хувь 1 хувь            ※ Төгсөлтийн гэрчилгээ бол хуулбар явуулах</p> <p>(2) Их сургууль(мэргэжлийн коллеж) төгссөнг батлах сүүлийн боловсролын гэрчилгээ эх хувь 1 хувь            ※ Апостиль гэрчилгээгээр авах            ※ Их сургууль(мэргэжлийн коллеж) төгссөн хүнд л хамаарана</p> <p>(3) Их сургууль(мэргэжлийн коллеж)-н дүн эх хувь 2 хувь</p>	Элсэлтийн бичиг баримтыг хугацаанд тааруулан авчирж өгөх эсвэл шуудангаар явуулах

## Элсэлтийн бичиг баримтны талаар анхаарах зүйлс

- A. Бүх бичиг баримт(иргэний үнэмлэх, гадаад паспорт зэрэг зарим бичиг баримтыг оруулахгүй)-г Солонгос эсвэл Англи хэл дээрх эх хувиар илгээх
  - ※ Элсэлтийн бичиг баримтны эх хувь нь Солонгос эсвэл Англи хэл дээр биш тохиолдолд солонгос, англи хэл дээр орчуулсан хувийг хамт өгөх
- B. Бичиг баримтыг эх хувь биш бол хуулбарыг нотариатаар батлуулж өгөх
- C. Дээр дурьдсан бичиг баримтууд нь их сургуульд элсэх бичиг баримтууд бөгөөд консул болон элчинд шаардлагатай бичиг баримтуудаа тусад нь бэлдэх шаардлагатай
- D. Элсэлтийн бичиг баримт нь өргөдөл гаргагчын нөхцөлөөс хамааран хэсгийг ярилцан тохиролцож болно
- E. Элсэлтийн бичиг баримтыг заасан хугацаанд багтаан өгөх шаардлагатай бөгөөд хугацаа хэтэрсэн тохиолдолд хүлээж авахгүй
- F. Бичиг баримт шалгах явцад хуурамч болон асуудалтай тохиолдол илэрвэл элсэлтийг хүлээн зөвшөөрөхгүй
- G. Өгсөн элсэлтийн бичиг баримтуудыг буцааж өгөхгүй

## 8. Өргөдөл гаргагчын анхаарах зүйл

- A. Өргөдөл дээрх хувийн мэдээлэл(англи нэр, төрсөн он сар өдөр зэрэг) нь гадаад паспорттой заавал таарах ёстой бөгөөд, анкет бөглөх явцад гарсан алдаанаас үүдсэн аливаа сул талыг өргөдөл гаргагч өөрөө хариуцана. Түүнчлэн элсэх өргөдөл гаргасны дараа мэдээллийг өөрчлөх боломжгүй
- B. Өргөдөл болон элсэлтийн баримт бичгийг буцаан олгохгүй
- C. Өргөдөл гаргах эрх болон элсэлтийн баримт бичгийг хуурамчаар үүлдэх болон гол асуудлыг орхигдуулах гэх мэт бусад хууль бус арга замаар тэнцсэн тохиолдолд тэнцсэн болон элсэн орсон(зөвшөөрөл)-г цуцлах болно
  - ※ Манай сургууль болон бусад их сургуулиас дээрх шалтгаанаар тэнцсэн мөн элсэн орсон(зөвшөөрөл) цуцлагдсан хүний хувьд тухайн өдрөөс хойш яг 3 жил өргөдөл гаргахад хязгаарлалт тавина
- D. Хэрэв элсэлтийн явцад(бичиг баримтыг шалгах гэх мэт) хууль бус, зохимжгүй зэрэг ямар нэгэн шалтгаан илэрсэн тохиолдолд тэнцэхгүй болно
- E. Мэдэгдсэн хугацаа(элсэлтийн баримт бичиг хураалгах, төлбөр төлөх зэрэг)-г заавал мөрдөх шаардлагатай
  - ※ Элсэлтийн бичиг баримтыг тогтоосон хугацаанд ирүүлээгүй бол хасах болно
  - ※ Тэнцэгч нь тогтоосон хугацаанд сургалтын төлбөрөө төлөөгүй бол тусад нь мэдэгдэлгүйгээр бүртгэлийг хүчингүй болгоно
- F. Элсүүлэн авах хүний тооноос хамааралгүй хэлний бэлтгэлд суралцах чадваргүй гэж үзвэл өргөдөл гаргагчыг Олон Улсын Боловсролын Солилцооны албаны удирдах хорооны шийдвэрээр элсэлтийг зөвшөөрөхгүй байж болно
- G. Эрх бүхий эсэхийг E-MAIL-ээр дамжуулан мэдэгдэнэ
- H. Ахлах сургуулиа төгсөх гэж буй хүн нь уг сургуулийн хэлний бэлтгэлд элсэн орох өдөр хүртэл тгөгсөж чадахгүй бол тэнцсэн мөн элсэн орсон(зөвшөөрөл)-г цуцлана
- I. БНСУ-ын Засгийн Газраас виз(VISA) олгох болон оршин суух эрхийг солихоос татгалзсан тохиолдолд элсэх гэрээг хүчингүй болгож төлбөрийг журмын дагуу буцаалт хийнэ
- J. Элсэлтийн бичиг баримт нь элсүүлэх удирдамжинд заасан байдлаар ирүүлэх ёстой бөгөөд, эс бөгөөс хүлээж авахгүй. Түүнчлэн их сургуулиас шаардлагатай байдлаас хамааран нэмэлт бичиг баримт шаардах тохиолдолд тэдгээрийг заасан хугацаанд ирүүлэх ёстой
  - ※ Элсэлтийн баримт бичиг нь өргөдөл гаргагчийн нөхцөл байдлаас шалтгаалан өөр байж болно
- K. Эрүүл мэндийн онцгой асуудал(халдварт өвчин гэх мэт) байвал элсэлт(зөвшөөрөл)-г цуцалж болно
  - ※ Гадаадад оршин суугчын хувьд мэндийн үзлэгийн гэрчилгээ(уушигны сүрьеэ хамаарана) хураалгах шаардлагатай
- L. Элсэлтийн өргөдөл өгөхийн өмнө заавал элсэлтийн удирдамжтай танилцах ёстой бөгөөд, уншиж танилцаагүйгээс үүдэн асуудал үүсвэл өргөдөл гаргагч өөрөө хариуцах болно
- M. Анкет болон элсэлтийн бичиг баримтан дээрх хувийн мэдээлэлийг 「Хувийн мэдээлэл цуглуулах ашиглах болон гуравдагч этгээдэд өгөхийг зөвшөөрөл」-н агуулгын дагуу цуглуулах/ашиглах бөгөөд, элсэгчийн хувийн мэдээллийг элсэн орсны дараа сургалттай холбоотойгоор ашиглах болно

N. Энэхүү элсэлтийн удирдамжинд багтаагүй Солонгос хэлний тэнхимийн элсэлттэй холбоотой зүйл байвал Сун Чон Хян Их Сургуулийн Олон Улсын Боловсрол Солилцооны албаны ажилтанд хандан шийдвэрлэн хийх

## 9. Сургалтын төлбөр болон дотуур байрны төлбөр

### A Сургалтын төлбөр

- ▶ 5,000,000вон(1,250,000вон X 4 улирал)
- ※ Солонгос соёлтой танилцах аялалын төлбөр орсон

### B Дотуур байрны төлбөр

- ▶ 1,968,000вон(хичээлийн 4 улиралд тулгуурласан)
- ※ Түлхүүрны барьцаа орсон, хоолны зардал ороогүй

### C Элсэлтийн үед төлөх хэмжээ

- ▶ Нийт 6,968,000вон(хичээлийн 4 улиралд тулгуурласан)

- ※ Элсэн орох үед төлөх хэмжээ бүртгүүлсэн улирлаас хамааран зарим нь өөр байж болно
- ※ Дээрх агуулгыг нөхцөл байдлаас хамааран хэсэгчлэн өөрчилж болно

## 10. Бусад зүйлийн талаарх танилцуулга

### A Анги дэвших болон ирц бүртгэлийн талаар

- 1) Анги дэвших жишиг : Улирал бүрийн ирцийн хувь 80% дээш болон дүнгийн дундаж 70 онооноос дээш
- 2) Оршин суух хугацаа(VISA) сунгах жишиг : Улирал бүрийн ирцийн хувь 70% дээш
- ※ Дээрх жишгийг хангаагүй тохиолдолд холбогдох журмын дагуу сургуулиас хасаж болно

### B Төлбөр буцаалт

- 1) Төлбөр буцаах журам

Буцаах шаардлага үүссэн тохиолдолд		Буцаан олгох хэмжээ
Хичээл эхлэхээс өмнө		Төлсөн сургалтын төлбөрийг бүрэн буцаана
Хичээл эхэлсний дараа		Буцах шалтгаан гарсан *тэр сарын буцаан олгох сургалтын төлбөр болон үлдсэн сарын сургалтын төлбөрийг буцаан өгнө
*Тэр сарын буцаан олгох сургалтын төлбөр	A) Хичээл эхлэхээс өмнө	Сургалтын төлбөрийг буцаана
	B) Тэр сарын нийт хичээлийн цагийн 1/3 өнгөрөхөөс өмнө	Тэр сарын сургалтын төлбөрийн 2/3-д хамаарах төлбөрийг буцаана
	C) Тэр сарын нийт хичээлийн цагийн 1/3 өнгөрсний дараа 1/2 өнгөрөхийн өмнө	Тэр сарын сургалтын төлбөрийн 1/2-д хамаарах төлбөрийг буцаана
	D) Тэр сарын нийт хичээлийн цагийн 1/2 өнгөрсний дараа	Тэр сарын сургалтын төлбөрийг буцаан олгохгүй

※ Дээрх нь нөхцөл байдлаас хамааран өөрчлөгдөж болно

## 2) Мэдэгдэл

- A) Гадаад дансруу төлбөр буцаах тохиолдолд валютын зөрүү болон үйлчилгээний хураамж зэргээс үүдэн төлсөн хэмжээтэй ялгаа үүсэж болно
- B) Төлбөр буцаахад 2~3 долоо хоног зарцуулагдана
- C) Виз(VISA) гаргах болон оршин суух эрхээ солиулахыг зөвшөөрөөгүй тохиолдолд элсэлтийг цуцлах бөгөөд дээрх бодлогийн дагуу төлбөрийг буцаана
- D) Сургуулиас гаргах, дээд сургуульд элсэх зэрэгт төлсөн сургалтын төлбөрийг дээрх журмын дагуу буцаан олгоно

# 11. Баримт бичиг бүрдүүлэн өгөх болон лавлах хаяг

## A Хаяг

- ▶ Солонгос хэл дээр : (31538) 대한민국 충청남도 아산시 신창면 순천향로 22-9, 순천향대학교 한국어교육원 B1301호
- ▶ Англи хэл дээр : B1301, Korean Language School, Soonchunhyang University, 22-9 Soonchunhyang-ro, Shinchang-myeon, Asan-si, Chungcheongnam-do, Republic of Korea(Postal Code : 31538)

## B Холбоо барих утас

- ▶ +82-41-530-1304, 1307

## C E-MAIL

- ▶ lkh3379@sch.ac.kr

## D Нүүр хуудас

- ▶ <http://sgee.sch.ac.kr>

※ Монгол хэл дээрх элсэлтийн удирдамжыг зөвхөн лавлагааны хувиар ашиглахыг хүсэх бөгөөд, Солонгос хэл дээрх элсэлтийн удирдамжны агуулгыг дагаж мөрдөхийг хүсье